



2021 оны 09 дүгээр сарын 09  
№34 /1184/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ







**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

311.	Патентын тухай /Шинэчилсэн найруулга/	2603
312.	Патентийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2690
313.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2691
314.	Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2694
315.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2695
316.	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2696
317.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай	2698
318.	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2700
319.	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2702

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПАТЕНТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт патент олгох, зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагаа болон аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршино.

#### 2 дугаар зүйл.Патентын хууль тогтоомж

2.1.Патентын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Оюуны өмчийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“албан ёсны тогтмол хэвлэл” гэж Оюуны өмчийн тухай хуулийн 3.1.4-т заасныг;

3.1.2.“анхдагч огноо” гэж энэ хуульд заасан шаардлагыг хангасан патентын мэдүүлгийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авсан он, сар, өдрийг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Оюуны өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 26 дугаарт нийтлэгдсэн.



3.1.3.“ашигтай загвар” гэж багаж, хэрэгсэл, түүнтэй адилтгах бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

3.1.4.“бүтээгдэхүүний загвар” гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн уран сайхны шийдлийг;

3.1.5.“бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал” гэж Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай 1968 оны Локарногийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Бүтээгдэхүүний загварын олон улсын ангиллыг;

3.1.6.“Гаагийн хэлэлцээр” гэж 1999 онд баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагийн хэлэлцээрийн Женевийн акт болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, зааврыг;

3.1.7.“давамгайлах огноо” гэж патентын мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг улсад гаргасан, Парисын конвенцын 4 дүгээр зүйлд заасан хугацаагаар тооцогдох нэг, эсхүл түүнээс дээш патентын мэдүүлгийн он, сар, өдрийг;

3.1.8.“зохион бүтээгч” гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар зохион бүтээсэн хувь хүнийг;

3.1.9.“олон улсын мэдүүлэг” гэж Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын патентын олон улсын мэдүүлгийг, эсхүл Гаагийн хэлэлцээрийн дагуу гаргасан бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн мэдүүлгийг;

3.1.10.“Парисын конвенц” гэж 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, өөрчлөн найруулсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцыг;

3.1.11.“патент” гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, патент эзэмшигч нь тодорхой хугацаанд энэ хуулийн 46.2-т заасан онцгой эрхийг эдлэх эрхийг;

3.1.12.“патентын мэдүүлэг” гэж иргэн, хуулийн этгээдээс энэ хуульд заасны дагуу гаргасан хүсэлт, өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг;



3.1.13.“патентын олон улсын ангилал” гэж 1971 оны Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын олон улсын ангиллыг;

3.1.14.“Патентын хамтын ажиллагааны гэрээ” гэж 1970 онд баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын хамтын ажиллагааны гэрээ болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, зааврыг;

3.1.15.“патент эзэмшигч” гэж патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг өмчлөх онцгой эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.16.“шинжээч” гэж Оюуны өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хүнийг;

3.1.17.“шинэ бүтээл” гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ХАМГААЛАЛ**

### **4 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын хамгаалалт**

4.1.Шинэ бүтээл, ашигтай загварыг энэ хуульд заасны дагуу оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “оюуны өмчийн байгууллага” гэх/-аас олгосон патентаар хамгаална.

### **5 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентаар хамгаалагдах зүйл, шалгуур**

5.1.Шинэ бүтээл болон шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой бүтээгдэхүүн, эсхүл арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг шинэ бүтээлд тооцож патентаар хамгаална.

5.2.Техникийн өмнөх түвшинд үл хамаарах техникийн шийдлийг шинэ гэж үзэж, дараах нөхцөлийг техникийн өмнөх түвшинд хамааруулна:

5.2.1.шинэ бүтээлийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө амаар, бичгээр, эсхүл бусад хэлбэрээр Монгол Улсад болон гадаад улсад нийтлэгдсэн, хэрэглэгдэж ирсэн, эсхүл нийтэд илэрхий болсон шийдэл, эсхүл мэдлэг;

5.2.2.шинэ бүтээлийн анхдагч огнооноос өмнө, эсхүл давамгайлах огнооноос өмнө бусад этгээдийн Монгол Улсад мэдүүлсэн,

албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн, патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар.

5.3.Шинэ бүтээлд хамаарах мэдээллийг мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө 12 сарын дотор зохион бүтээгч, эсхүл уг мэдээллийг шууд буюу шууд бусаар олж авсан этгээд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд илэрхий болгосон бол энэ нь шинэ гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд мэдүүлэг гаргагч үүнийг нотлох үүрэгтэй.

5.4.Шинэ бүтээлээр дэвшүүлсэн шийдлийг анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад холбогдох мэргэжлийн хүнд илэрхий ялгарах давуу шинж чанартай байвал шинэ бүтээлийн түвшин агуулсан гэж үзнэ. Шинэ бүтээлийн түвшинг тогтооход энэ хуулийн 5.3-т заасныг техникийн өмнөх түвшинд хамааруулахгүй.

5.5.Шинэ бүтээлийг үйлдвэрлэлийн аливаа салбарт үйлдвэрлэж, эсхүл ашиглаж болохуйц байвал үйлдвэрлэлд ашиглах боломжтой гэж үзнэ.

## **6 дугаар зүйл.Шинэ бүтээлд тооцохгүй зүйл**

6.1.Дараах зүйлийг шинэ бүтээлд тооцохгүй:

6.1.1.нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга;  
6.1.2.компьютерын программ, алгоритм дангаараа;  
6.1.3.аж ахуйн ба бизнесийн үйл ажиллагаа, боловсрол, сургалтын арга, зөвхөн оюуны үйлдэл хийх, тоглоом тоглоход зориулагдсан бүүдүүвч, дүрэм, аргачлал;

6.1.4.барилга байгууламж, газар, талбайн төлөвлөлт, зохион байгуулалт;

6.1.5.бүтээгдэхүүний гаднах хийц, хэлбэрт хамаарах уран сайхны шийдэл.

6.2.Компьютерын программ, алгоритм нь шинэ бүтээлийн бүрэлдэхүүн хэсэг байх нь түүнийг патентаар хамгаалахгүй байх нөхцөл болохгүй.

## **7 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патент олгохгүй зүйл**

7.1.Дараах зүйлд шинэ бүтээлийн патент олгохгүй:

7.1.1.шинэ бүтээлийг нийтлэх, эсхүл эдийн засгийн эргэлтэд оруулах нь нийгмийн дэг журам, зан суртахуун, хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд харш бол;



7.1.2.бичил биетнээс бусад ургамал, амьтан, тэдгээрийн хэсэг, түүнчлэн ургамал, амьтан, тэдгээрийн хэсгийг бий болгох биологийн үндсэн арга;

7.1.3.ургамлын сорт, амьтны үүлдэр;

7.1.4.хүн, амьтны биед хэрэглэх эмчилгээ, мэс засал ба оношилгооны арга;

7.1.5.хүн, амьтны клон гаргаж авах арга, эсийн генийн төрөлх байдлыг өөрчлөх арга, хүний үр хөврөлийг үйлдвэрлэлийн болон арилжааны зорилгоор хэрэглэх арга.

7.2.Энэ хуулийн 7.1.2-т биологийн бус болон микробиологийн арга, ажиллагаа хамаарахгүй.

7.3.Энэ хуулийн 7.1.4-т хүн, мал, амьтны биед хэрэглэх эмчилгээний горим, мэс засал, эсхүл оношилгоонд хэрэглэгдэх бүтээгдэхүүн, оношлуур, төхөөрөмж, бодис, нийлэмж болон найрлага хамаарахгүй.

## **8 дугаар зүйл.Ашигтай загварын патентаар хамгаалагдах зүйл, шалгуур**

8.1.Шинэ, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шийдлийг ашигтай загварт тооцож патентаар хамгаална.

8.2.Ашигтай загвар нь шинэ байх бөгөөд үүнийг энэ хуулийн 5.2-т зааснаар ойлгоно.

8.3.Ашигтай загварыг үйлдвэрлэлд ашиглах боломжтой байх бөгөөд үүнийг энэ хуулийн 5.5-д зааснаар ойлгоно.

## **9 дүгээр зүйл.Ашигтай загварт тооцохгүй зүйл**

9.1.Энэ хуулийн 6.1-д заасан зүйлийг ашигтай загварт тооцохгүй.

9.2.Энэ хуулийн 6.2-т заасан зүйл нь ашигтай загварт нэгэн адил хамаарна.

## **10 дугаар зүйл.Ашигтай загварын патент олгохгүй зүйл**

10.1.Дараах зүйлд ашигтай загварын патент олгохгүй:

10.1.1.арга, ажиллагаа;

10.1.2.бодис, найрлага, химийн нэгдэл;

10.1.3.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шийдэл.

## **11 дүгээр зүйл. Патент авах эрх**

11.1. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээгч, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд патент авах эрхтэй байна.

11.2. Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг ажил олгогч эдэлнэ.

11.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний үндсэн дээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загварт патент авах эрхийг захиалагч, эсхүл санхүүжүүлэгч этгээд эдэлнэ.

11.4. Шинэ бүтээл, ашигтай загварыг хамтран зохион бүтээсэн бол патент авах эрхийг хамтран эдэлнэ. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээхэд техникийн, зохион байгуулалтын, эсхүл санхүүгийн туслалцаа үзүүлсэн, эсхүл патентын мэдүүлэг гаргах, патент авахад дэмжлэг үзүүлсэн этгээдийг хамтран зохион бүтээгч гэж тооцохгүй.

11.5. Ижил шинэ бүтээл, ашигтай загварыг бие даан тусдаа зохион бүтээсэн бол патент авах эрхийг патентын мэдүүлгийг түрүүлж гаргасан этгээд эдэлнэ.

## **12 дугаар зүйл. Ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар**

12.1. Шинэ бүтээл, ашигтай загварыг дараах тохиолдолд ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загвар гэж үзнэ:

12.1.1. ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад зохион бүтээсэн;

12.1.2. ажил олгогчийн өгсөн албан даалгаврыг биелүүлэх явцад зохион бүтээсэн;

12.1.3. ажил олгогчийн технологи, төхөөрөмж, эд хөрөнгө, мэдээлэл, туршлага зэрэг нөөцийг ашиглаж зохион бүтээсэн.

12.2. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн ажилтан энэ тухай ажил олгогчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

12.3. Ажил олгогч патентын мэдүүлэг гаргахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор патентын мэдүүлэг гаргаагүй бол патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ.

12.4.Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээх үүргийг хөдөлмөрийн гэрээгээр ажилтанд хүлээлгэж, зохих цалин хөлс олгож байснаас бусад тохиолдолд ажлын байранд зохион бүтээгдсэн шинэ бүтээл, ашигтай загварын патентыг ажил олгогч авахыг хүсвэл зохион бүтээгч ажилтантай гэрээ байгуулж, зохих төлбөр төлнө.

12.5.Ажил олгогч нь ажлын байран дахь шинэ бүтээл, ашигтай загварын патент авсан өдрөөс хойш зургаан сарын дотор, эсхүл патент авахаас өмнө шинэ бүтээл, ашигтай загварыг ашиглаж эхэлсэн бол үүнээс хойш нэг жилийн дотор зохион бүтээгч ажилтантай энэ хуулийн 12.4-т заасан гэрээ байгуулах бөгөөд уг гэрээгээр төлбөр төлөх нөхцөл, хэмжээ, түүнийг олгох журмыг тусгана. Төлбөрийн хэмжээг тогтооход тухайн шинэ бүтээл, ашигтай загварын эдийн засгийн үнэлгээ, ашигласнаас олох үр ашиг, талуудын оруулсан хувь нэмэр зэргийг харгалзана.

12.6.Энэ хуулийн 12.4-т заасан гэрээг байгуулаагүй бол төлбөрийн хэмжээг тогтоолгох, гэрээ байгуулахыг даалгуулахаар ажилтан шүүхэд хандаж болно.

12.7.Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг зохион бүтээгч ажилтан эдэлнэ.

### **13 дугаар зүйл.Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загвар**

13.1.Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээсэн бол энэ тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

13.2.Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч эдэлнэ.

13.3.Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон шинэ бүтээл, ашигтай загварт патент авах эрхийг зохион бүтээгч эдлэхээр гэрээнд заасан бол патент авах эрхийг эрх шилжүүлэх гэрээний үндсэн дээр зохион бүтээгчид шилжүүлнэ.

13.4.Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загварын

патент авах эрхийг захиалагч төрийг төлөөлж эдэлнэ. Захиалагч энэ хуулийн 13.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дотор оюуны өмчийн байгууллагад патентын мэдүүлэг гаргах бөгөөд энэ хугацаанд патентын мэдүүлэг гаргаагүй бол патент авах эрхийг зохион бүтээгч эдэлнэ.

#### **14 дүгээр зүйл.Зохион бүтээгчийн нэрийг дурдах**

14.1.Зохион бүтээгч нэрээ дурдуулахаас татгалзсан тухай оюуны өмчийн байгууллагад бичгээр мэдэгдсэнээс бусад тохиолдолд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, патент, албан ёсны тогтмол хэвлэлд зохион бүтээгчийн нэрийг дурдана.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛЭГ, ТҮҮНД ХАЙЛТ, ШҮҮЛТ ХИЙХ**

#### **15 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг гаргах**

15.1.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 11.1-д заасан этгээд оюуны өмчийн байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

15.2.Мэдүүлэг гаргагч патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

15.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, эсхүл үйл ажиллагаа эрхэлдэггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, эсхүл гадаад улсын хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлнэ.

15.4.Шинэ бүтээл тус бүрд нэг патентын мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах хоёр, эсхүл түүнээс дээш шинэ бүтээлд нэг патентын мэдүүлэг гаргаж болно.

15.5.Ашигтай загвар тус бүрд нэг патентын мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах хоёр, эсхүл түүнээс дээш ашигтай загварт нэг патентын мэдүүлэг гаргаж болно.

#### **16 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг**

16.1.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг дараах зүйлээс бүрдэнэ:



16.1.1.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

16.1.2.тодорхойлолт;

16.1.3.томьёолол;

16.1.4.шаардлагатай тохиолдолд шинэ бүтээл, ашигтай загварын мөн чанарыг тайлбарласан зураг, бүдүүвч;

16.1.5.товч тайлбар;

16.1.6.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

16.1.7.зохион бүтээгч бус этгээд патентын мэдүүлэг гаргах бол патентын мэдүүлэг гаргах эрхээ нотолсон баримт;

16.1.8.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;

16.1.9.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэл;

16.1.10.давамгайлах эрх хүссэн бол үүнийг нотлох баримт.

16.2.Энэ хуулийн 16.1.1-д заасан өргөдөлд дараах зүйлийг тусгана:

16.2.1.патент авах тухай хүсэлт;

16.2.2.шинэ бүтээл, ашигтай загварын нэр;

16.2.3.патентын олон улсын ангилал;

16.2.4.мэдүүлэг гаргагч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа газрын хаяг, иргэний харьяалал, гарын үсэг;

16.2.5.мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, өмчийн хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

16.2.6.зохион бүтээгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа газрын хаяг, иргэний харьяалал;

16.2.7.патент эзэмшигч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, байнга оршин суугаа газрын хаяг, иргэний харьяалал, гарын үсэг;

16.2.8.патент эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, өмчийн хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

16.2.9.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг, гарын үсэг;

16.2.10.давамгайлах эрх хүсэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл;

16.2.11.хавсаргасан баримт бичгийн жагсаалт, хуудасны тоо.

16.3.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.

16.4.Шинэ бүтээл, ашигтай загварыг мэдүүлэхдээ энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.5-д заасныг өөр хэлээр гаргасан тохиолдолд патентын мэдүүлэг гаргасан өдрөөс хойш хоёр сарын дотор монгол хэлээр орчуулж ирүүлнэ.

16.5.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 16.4-т заасан хугацааг нэг сараар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

16.6.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.5-д заасныг энэ хуулийн 16.4, 16.5-д заасан хугацааны дотор монгол хэлээр орчуулж ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгож, энэ тухай мэдүүлэг гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

16.7.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 16.1.7, 16.1.8, 16.1.9-д заасан баримт бичгийг шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг гаргах үед, эсхүл патентын мэдүүлэг гаргасан өдрөөс хойш хоёр сарын дотор ирүүлнэ.

16.8.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 16.7-д заасан хугацааг нэг сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

16.9.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгт тавих шаардлага, патентын мэдүүлгийг бүртгэх, тэдгээрт өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг оюуны өмчийн байгууллага батална.

## **17 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт**

17.1.Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт нь тухайн шийдлийн техникийн өмнөх түвшнээс онцгой ялгарах шинж чанарыг тусгаж, хамаарах салбарын мэргэжлийн хүн хэрэгжүүлж болохуйц байдлаар бүрэн, тодорхой тайлбарлан бичсэн мэдээлэл байна. Шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолтод дараах зүйлийг тусгана:

- 17.1.1.шийдлийн нэр;
- 17.1.2.шийдлийн хамаарах болон ашиглагдах салбар;
- 17.1.3.дэвшүүлж байгаа шийдэлтэй төсөөтэй шийдлийн

мөн чанар;

- 17.1.4.төсөөтэй шийдлүүдийн дутагдал;
- 17.1.5.дэвшүүлж байгаа шийдлийн зорилго;
- 17.1.6.дэвшүүлж байгаа шийдлийн мөн чанар;
- 17.1.7.шийдлийг бодитоор хэрэгжүүлэх арга;
- 17.1.8.шаардлагатай тохиолдолд шийдлийн мөн чанарыг

тайлбарлах зураг.

17.2.Шинэ бүтээл, ашигтай загварын нэр нь товч, тодорхой, патентын олон улсын холбогдох ангилалд хамаарах нэр томъёог баримталсан байх бөгөөд хийсвэр, эсхүл бэлгэдлийн шинжтэй байж болохгүй.

17.3.Шинэ бүтээлийг бүтээхэд Монгол Улсын биологийн, эсхүл генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг шууд болон шууд бусаар ашигласан, эсхүл шинэ бүтээлийг ашиглахад хэрэглэх бол эдгээрийн гарал үүслийг шинэ бүтээлийн тодорхойлолтод онцлон зааж өгнө.

17.4.Шинэ бүтээлийг бүтээхэд ашигласан, эсхүл шинэ бүтээлийг ашиглахад хэрэглэх Монгол Улсын биологийн, эсхүл генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг тодорхойлолтод заагаагүй, эсхүл худал мэдээлэл өгсөн нь оюуны өмчийн байгууллага патент олгохоос татгалзах, эсхүл олгосон патентыг хүчингүй болгох үндэслэл болно.

## **18 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын томъёолол**

18.1.Шинэ бүтээл, ашигтай загвар нь нэг, эсхүл түүнээс дээш үндсэн томъёололтой, үндсэн томъёоллоос хамаарах нэг, эсхүл түүнээс дээш туслах томъёололтой байж болно.

18.2.Шинэ бүтээл, ашигтай загварын томъёолол нь дараах шаардлагыг хангасан байна:



18.2.1. тухайн шинэ бүтээл, ашигтай загварын онцгой ялгарах шинж чанар, эрхийн хамгаалалтын хүрээг тодорхойлсон, ойлгомжтой, товч байх;

18.2.2. томъёололд дурдагдсан шинж чанар нь тодорхойлолтод бүрэн тусгагдсан байх.

### **19 дүгээр зүйл. Товч тайлбар**

19.1. Товч тайлбар нь шинэ бүтээл, ашигтай загварын талаар техникийн мэдээлэл өгөх зорилготой байна.

19.2. Ашигтай загварын товч тайлбарт ашигтай загварын үндсэн шинжийг илэрхийлсэн зураг хавсаргана.

19.3. Шаардлагатай бол шинэ бүтээлийн товч тайлбарт түүний үндсэн шинжийг илэрхийлсэн зураг хавсаргаж болно.

### **20 дугаар зүйл. Зураг, бүдүүвч**

20.1. Шинэ бүтээлийн мөн чанарыг бүрэн тайлбарлахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд шинэ бүтээлийн зураг, эсхүл технологийн бүдүүвчийг хавсаргана.

20.2. Ашигтай загварын мөн чанарыг бүрэн тайлбарлахад шаардлагатай тооны зургийг хавсаргана.

### **21 дүгээр зүйл. Давамгайлах эрх хүсэх, давамгайлах эрхийг хүлээн зөвшөөрөх**

21.1. Мэдүүлэг гаргагч патентын мэдүүлэгтээ Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсад гаргасан давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон нэг, эсхүл түүнээс дээш шинэ бүтээлийн, эсхүл ашигтай загварын патентын мэдүүлэгт үндэслэн Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу давамгайлах эрх хүсэж болно.

21.2. Энэ хуулийн 21.1-д заасан давамгайлах эрх нь 12 сарын хугацаатай байх бөгөөд уг хугацааг Парисын конвенцын дагуу тооцно.

21.3. Мэдүүлэг гаргагч анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор давамгайлах эрх хүсэж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

21.4. Давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон патентын мэдүүлэг нь энэ хуулийн 21.1-д заасан аль нэг улсад гаргасан, эсхүл Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээлийн, эсхүл ашигтай загварын патентын олон улсын мэдүүлэг байна.

21.5. Мэдүүлэг гаргагч патентын мэдүүлэгтээ давамгайлах эрх хүссэн бол патентын мэдүүлгийг хүлээн авсан байгууллагаас олгосон давамгайлах эрхтэй болохыг нотлох баримтыг хавсаргана.

21.6. Мэдүүлэг гаргагч Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан албан ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын үзэсгэлэнд шинэ бүтээл, ашигтай загварыг нийтэд дэлгэсэн бол нийтэд дэлгэсэн өдрөөс хойш 12 сарын дотор үзэсгэлэнгийн давамгайлах эрх хүсэж болно.

21.7. Давамгайлах огноог нотлох баримтыг патентын мэдүүлэгт хавсаргах бөгөөд хавсаргаагүй бол патентын мэдүүлэг гаргасан өдрөөс хойш хоёр сарын дотор ирүүлж болно. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол мэдүүлэг гаргагч энэ хугацааг гурав хүртэл сараар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

21.8. Энэ хуулийн 21.7-д заасан хугацаанд давамгайлах огноог нотлох баримтыг ирүүлээгүй бол давамгайлах эрх хүсээгүйд тооцно.

## **22 дугаар зүйл. Шинэ бүтээл, ашигтай загварын анхдагч огноог тогтоох, мэдүүлгийн бүрдлийн шүүлт хийх**

22.1. Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор мэдүүлэг гаргагчид, эсхүл оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/-д мэдүүлэг хүлээн авсан тухай мэдэгдэл хүргүүлнэ.

22.2. Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 16, 21 дүгээр зүйлд заасан бүрдэл хангасан эсэхийг патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хянана.

22.3. Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтоож, мэдүүлгийн улсын бүртгэлд бүртгэсэн тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.



22.4. Оюуны өмчийн байгууллага нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирүүлнэ.

22.5. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 22.4-т заасан хугацааг гурван сар хүртэл хугацаагаар сунгуулах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.6. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 22.4, 22.5-д заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулж ирүүлээгүй бол оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгосон тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

22.7. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 22.5, 22.6-д заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулж ирүүлсэн боловч энэ нь мэдүүлгийн бүрдлийн шаардлага хангаагүй бол оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчид бүрдэл хангуулах тухай шаардлагыг мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.8. Оюуны өмчийн байгууллага нь патентын мэдүүлэг энэ хуулийн 6, 7, 9, 10, 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор шинэ бүтээлийн мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг энэ хуулийн 22.2-т заасан шаардлагыг хангасан өдрөөс хойш дөрвөн сарын дотор, ашигтай загварын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг энэ хуулийн 22.2-т заасан шаардлагыг хангасан өдрөөс хойш хоёр сарын дотор хийнэ.

22.9. Дэвшүүлж байгаа шинэ бүтээл, ашигтай загвар нь энэ хуулийн 6, 7, 9, 10 дугаар зүйлд заасан шалгуурыг хангаагүй бол оюуны өмчийн байгууллага нь патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгож, мэдүүлэг гаргагчид мэдэгдэл хүргүүлнэ.

22.10. Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загварын тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвч нь энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл патентын мэдүүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

22.11. Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 22.10-т заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор нэмэлт, өөрчлөлт оруулж

ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцно. Энэ тухай мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

22.12.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 22.11-д заасан хугацааг шинэ бүтээлийн хувьд гурван сар хүртэл хугацаагаар, ашигтай загварын хувьд нэг сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.13.Энэ хуулийн 22.11, 22.12-т заасан хугацааны дотор ирүүлсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй бол энэ тухай оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчид мэдэгдэх ба мэдүүлэг гаргагч уг шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийж ирүүлнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

22.14.Энэ хуулийн 22.13-т заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулж ирүүлээгүй бол мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид мэдэгдэл хүргүүлнэ.

22.15.Патентын мэдүүлгийг энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл энэ тухай патентын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийн дүгнэлт гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

22.16.Оюуны өмчийн байгууллага энэ хуулийн 22.1, 22.3, 22.4, 22.6, 22.7, 22.9, 22.10, 22.11, 22.13, 22.14, 22.15-д заасан мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

### **23 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг салгах, нэгтгэх, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, татгалзах**

23.1.Мэдүүлэг гаргагч нь анхдагч огнооноос хойш мөн чанарын шүүлтийн явцын хэдийд ч анх мэдүүлсэн тодорхойлолтын агуулга, томьёоллын хүрээнд дараах өөрчлөлтийг оруулж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө:

23.1.1.патентын мэдүүлгээ хоёр ба түүнээс дээш патентын мэдүүлэгт салгах тухай хүсэлт гаргах;

23.1.2.хамтаар ашиглагдах шинэ бүтээлийн хэд хэдэн патентын мэдүүлгийг нэгтгэх;

23.1.3.хамтаар ашиглагдах ашигтай загварын хэд хэдэн патентын мэдүүлгийг нэгтгэх;

23.1.4.патентын мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт оруулах;

23.1.5.энэ хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан шинэ бүтээлийн мэдүүлгийг ашигтай загварын патентын мэдүүлэгт шилжүүлэх;

23.1.6.энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан ашигтай загварын патентын мэдүүлгийг шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт шилжүүлэх.

23.2.Салгасан патентын мэдүүлэг тус бүр үндсэн патентын мэдүүлгийн анхдагч болон давамгайлах огноо авах эрхтэй. Салгасан патентын мэдүүлэг тус бүрд үйлчилгээний хөлс төлнө.

23.3.Мэдүүлэг гаргагч нь анхдагч огнооноос мөн чанарын шүүлтийн явцын хэдийд ч патентын мэдүүлгээсээ татгалзаж, хэрэгсэхгүй болгуулж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-д заасны дагуу хэрэгсэхгүй болсон патентын мэдүүлэг нь нийтэд илэрхий болоогүй бол тухайн патентын мэдүүлгийг техникийн өмнөх түвшинд хамааруулахгүй бөгөөд тухайн шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг дахин гаргаж болно.

23.5.Энэ хуулийн 23.1-д заасан өөрчлөлт нь анх ирүүлсэн тодорхойлолтын агуулгыг өөрчлөхөөр бол шинээр мэдүүлэг гаргана.

#### **24 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгт хайлт хийх, нийтэд мэдээлэх**

24.1.Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загварын техникийн өмнөх түвшинг тогтоох зорилгоор хайлт хийж, тайлан гаргана.

24.2.Энэ хуулийн 22.15-д заасан мэдүүлгийн бүрдлийн шүүлтийн дүгнэлт гарсан өдрөөс хойш шинэ бүтээлийн хайлтын тайланг есөн сарын дотор, ашигтай загварын хайлтын тайланг нэг сарын дотор гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

24.3.Мэдүүлэг гаргагч нь хайлтын тайлан хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгтээ тодорхойлолтын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

24.4.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 24.3-т заасан хугацааг гурав хүртэл сараар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.



24.5.Хайлтын тайлан нь шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгох, эсхүл патент олгохоос татгалзах үндэслэл болохгүй.

24.6.Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээлийн хайлтын тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг хайлтын тайлангийн хамт албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

24.7.Оюуны өмчийн байгууллага энэ хуулийн 24.6-д заасны дагуу түүнийг нийтлэхээс өмнө патентын мэдүүлгийн талаар гуравдагч этгээдэд мэдээлэл өгөхгүй бөгөөд патентын мэдүүлгийн агуулгыг нууцална.

24.8.Албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн шинэ бүтээлийг патент олгох хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авах бөгөөд энэ хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр уг шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

### **25 дугаар зүйл.Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх**

25.1.Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлтийг мэдүүлэг гаргагчийн хүсэлтийг үндэслэн хийнэ.

25.2.Мэдүүлэг гаргагч нь мөн чанарын шүүлт хийлгэх тухай хүсэлтийг анхдагч огнооноос хойш 15 сарын дотор оюуны өмчийн байгууллагад гаргах бөгөөд үйлчилгээний хөлс төлнө.

25.3.Оюуны өмчийн байгууллага нь энэ хуулийн 25.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан бол шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлтийг энэ хуулийн 24.6-д заасны дагуу албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 12 сарын дотор хийж гүйцэтгэнэ.

25.4.Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор оюуны өмчийн байгууллага мөн чанарын шүүлт хийж, тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.5.Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан бол мөн чанарын шүүлтийн тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор оюуны өмчийн байгууллага шинэ

бүтээлийн ном зүй, товч тайлбар, тодорхойлолт, томьёоллыг албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

25.6.Мөн чанарын шүүлтийн явцад патентын мэдүүлэгт энэ хуулийн 17, 18, 19, 20, 23 дугаар зүйлд заасан шаардлагад хамаарах болон бусад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шинжээч үзвэл энэ тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.7.Мөн чанарын шүүлт хийх явцад олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч болно.

25.8.Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй бол патент олгохоос татгалзаж, мөн чанарын шүүлтийн тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.9.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 25.8-д заасан тайланг эс зөвшөөрвөл түүнийг хүлээж авсан өдрөөс хойш нэг сарын дотор үндэслэл бүхий хариуг оюуны өмчийн байгууллагад ирүүлнэ.

25.10.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 25.9-д заасан хугацааг гурав хүртэл сараар сунгуулах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

25.11.Оюуны өмчийн байгууллага энэ хуулийн 25.9-д заасан хариуг хүлээж авснаас хойш нэг сарын дотор шинэ бүтээлийн патентын мэдүүлгийг дахин хянаж, зохих нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэ тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.12.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 25.6, 25.11-д заасан мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс хойш нэг сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлтийг хийж ирүүлэх бөгөөд мэдүүлэг гаргагч энэ хугацааг гурав хүртэл сараар сунгуулах хүсэлт гаргаж болно.

25.13.Энэ хуулийн 25.12-т заасан хугацаанд зохих нэмэлт, өөрчлөлтийг хийж ирүүлээгүй бол оюуны өмчийн байгууллага эцсийн дүгнэлт гаргаж, холбогдох шийдвэрийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

25.14.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх журмыг оюуны өмчийн байгууллага батална.

## **26 дугаар зүйл. Ашигтай загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх**

26.1.Оюуны өмчийн байгууллага хайлтын тайланг эцэслэн гаргасан өдрөөс хойш гурван сарын дотор ашигтай загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийнэ.



26.2.Дэвшүүлж байгаа ашигтай загварын шийдэл нь энэ хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор оюуны өмчийн байгууллага мөн чанарын шүүлт хийж, тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

26.3.Дэвшүүлж байгаа ашигтай загварын шийдэл нь энэ хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан бол мөн чанарын шүүлтийн тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор оюуны өмчийн байгууллага ашигтай загварын ном зүй, товч тайлбар, тодорхойлолт, томьёоллыг мөн чанарын шүүлтийн тайлангийн хамт албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

26.4.Мөн чанарын шүүлтийн явцад патентын мэдүүлэгт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шинжээч үзвэл энэ тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

26.5.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 26.4-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор мэдүүлэгт зохих нэмэлт, өөрчлөлтийг хийж ирүүлнэ.

26.6.Энэ хуулийн 26.5-д заасан зохих нэмэлт, өөрчлөлтийг хүлээж авснаас хойш нэг сарын дотор шинжээч тухайн ашигтай загварын мэдүүлэгт патент олгох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргаж, мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

26.7.Энэ хуулийн 26.5-д заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд шинжээч тухайн ашигтай загварын мэдүүлэгт патент олгох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргаж, шийдвэрийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ХАМГААЛАЛТ**

### **27 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын хамгаалалт**

27.1.Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварыг энэ хуульд заасны дагуу олгосон патентаар хамгаална.

### **28 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентаар хамгаалагдах зүйл, шалгуур**

28.1.Бүтээгдэхүүний загвар нь шинэ болон өвөрмөц шинжийг агуулсан бол патентаар хамгаалагдана.

28.2.Бүтээгдэхүүний загварын шийдэл нь анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө Монгол Улсад болон гадаад улсад нийтэд илэрхий болоогүй бол шинэ гэж үзнэ.

28.3.Бүтээгдэхүүний загварын шийдлийн гадаад гоо зүйн онцлог шинж чанар нь оюуны бүтээлч шинжийг агуулж байвал түүнийг өвөрмөц шинжтэй гэж үзнэ.

28.4.Бүтээгдэхүүний загварыг, эсхүл түүнд хамаарах мэдээллийг зохион бүтээгч буюу мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл уг мэдээллийг шууд буюу шууд бусаар олж авсан этгээд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд илэрхий болгосон хэдий ч мэдүүлэг гаргах эрх бүхий этгээд тэрхүү өдрөөс хойш зургаан сарын дотор уг бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь шинэ гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд мэдүүлэг гаргагч үүнийг нотлох үүрэгтэй.

### **29 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварт тооцохгүй зүйл**

29.1.Монгол Улсын төрийн сүлд, туг, далбаа, тамга, шагнал, одон, медаль болон гадаад улсын төрийн бэлгэ тэмдэг, далбаа, сүлд, Монгол Улсын төрийн байгууллагын албан ёсны бэлгэ тэмдэг, тусгай тэмдэгт болон баталгаа, хяналтын тэмдэг, мөнгөн тэмдэгтээс бүрдсэн, эсхүл тэдгээртэй ижил, төсөөтэй загварыг бүтээгдэхүүний загварт тооцохгүй.

### **30 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патент олгохгүй зүйл**

30.1.Дараах зүйлд бүтээгдэхүүний загварын патент олгохгүй:

30.1.1.бүтээгдэхүүний загварын шийдэл нь бүтээгдэхүүний техникийн болон үндсэн зориулалтад хамаарах бол;

30.1.2.бүтээгдэхүүний загвар нь бүртгэгдсэн барааны тэмдгээс бүрдсэн бол;

30.1.3.бүтээгдэхүүний загвар нь зохиогчийн эрхийг зөрчихөөр бол;

30.1.4.нийгмийн дэг журам, зан суртахуунд харш бол.

### **31 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварын патент авах эрх, зохион бүтээгчийн нэрийг дурдах**

31.1.Бүтээгдэхүүний загвар зохион бүтээгч, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд бүтээгдэхүүний загварын патент авах эрхтэй.

31.2.Бүтээгдэхүүний загварын патент авахад энэ хуулийн 11, 12, 13 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

### **32 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргах**

32.1.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 31.1-д заасан этгээд оюуны өмчийн байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

32.2.Мэдүүлэг гаргагч бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

32.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй, эсхүл үйл ажиллагаа эрхэлдэггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, эсхүл гадаад улсын хуулийн этгээд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлнэ.

### **33 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг**

33.1.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг дараах зүйлээс бүрдэнэ:

33.1.1.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

33.1.2.бүтээгдэхүүний загварын зураг;

33.1.3.бүтээгдэхүүний загварын тодорхойлолт;

33.1.4.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;

33.1.5.зохион бүтээгчээс бусад этгээд патентын мэдүүлэг гаргах бол патент авах эрхээ нотолсон баримт;

33.1.6.мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн бол итгэмжлэл;

33.1.7.давамгайлах эрх хүссэн бол үүнийг нотлох баримт;

33.1.8.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

33.1.9.хавсаргасан баримт бичгийн жагсаалт, хуудасны

тоо.

33.2.Энэ хуулийн 33.1.1-д заасан өргөдөлд дараах зүйлийг тусгана:

33.2.1.бүтээгдэхүүний загварын патент авах тухай хүсэлт;  
33.2.2.бүтээгдэхүүний загварыг илэрхийлэх ерөнхий нэр;  
33.2.3.бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал;  
33.2.4. бүтээгдэхүүний загварын тоо;  
33.2.5.мэдүүлэг гаргагч нь хувь хүн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг улсын нэр, гарын үсэг;

33.2.6.мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, хэлбэр, албан ёсны хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

33.2.7.зохион бүтээгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг улсын нэр;

33.2.8.мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг, гарын үсэг;

33.2.9.давамгайлах эрх хүсэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл.

33.3.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ.

33.4.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасан баримт бичгийг бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргах үед, эсхүл патентын мэдүүлэг гаргасан өдрөөс хойш хоёр сарын дотор ирүүлнэ.

33.5.Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 33.4-т заасан хугацааг нэг сар хүртэл хугацаагаар сунгуулах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

33.6.Энэ хуулийн 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасан зохион бүтээгчийн баталгаа, нотлох баримт, итгэмжлэлийг энэ хуулийн 33.4, 33.5-д заасан хугацаанд оюуны өмчийн байгууллагад ирүүлээгүй бол патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, оюуны өмчийн байгууллага патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгож, энэ тухай мэдүүлэг гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

33.7.Бүтээгдэхүүний загварын нэр нь товч, тодорхой, бүтээгдэхүүний загварын олон улсын ангилалд хамаарах нэр томьёог

баримталсан байх бөгөөд хийсвэр, эсхүл бэлгэдлийн шинжтэй байж болохгүй.

33.8.Бүтээгдэхүүний загварын тодорхойлолтод тухайн бүтээгдэхүүний загварын гадаад дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн шинэ болон өвөрмөц шинжийг тодорхойлон бичнэ.

33.9.Бүтээгдэхүүний загварын зураг нь тухайн бүтээгдэхүүний загварын шинэ болон өвөрмөц шинжийг бүрэн харуулсан байна.

33.10.Бүтээгдэхүүний загварын олон улсын нэг ангилалд хамаарах 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг патентын мэдүүлгээр мэдүүлж болно.

33.11.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт тавих шаардлага, патентын мэдүүлэг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг оюуны өмчийн байгууллага батална.

#### **34 дүгээр зүйл.Бүтээгдэхүүний загварын давамгайлах огноо**

34.1.Мэдүүлэг гаргагч нь патентын мэдүүлэгтээ Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсад гаргасан давамгайлах эрх үүсэх үндэслэл болсон өмнөх нэг, эсхүл түүнээс дээш патентын мэдүүлэгт үндэслэн Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу давамгайлах эрх хүсэж болно.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан давамгайлах эрх олгогдох хугацаа нь зургаан сар байх бөгөөд уг хугацааг Парисын конвенцын 4 дүгээр зүйлийн дагуу тооцно.

34.3.Мэдүүлэг гаргагч нь Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан албан ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын үзэсгэлэнд бүтээгдэхүүний загварыг нийтэд дэлгэсэн бол нийтэд дэлгэсэн өдрөөс хойш зургаан сарын дотор үзэсгэлэнгийн давамгайлах эрх хүсэж болно.

34.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 34.1, 34.3-т заасан эрхийг хүссэн бол энэ тухай нотлох баримтыг патентын мэдүүлэгтээ хавсаргана.

34.5.Энэ зүйлд энэ хуулийн 21.7, 21.8 дахь хэсэг нэгэн адил хамаарна.

**35 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг хүлээн авах, анхдагч огноо тогтоох**

35.1. Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор патентын мэдүүлэг хүлээн авсан тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүргүүлнэ.

35.2. Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг патентын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хянана.

35.3. Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл патентын мэдүүлэг хүлээн авсан өдрөөр анхдагч огноо тогтоож, патентын мэдүүлгийн улсын бүртгэлд бүртгэсэн тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

35.4. Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл нэг сарын дотор зохих нэмэлт, өөрчлөлт хийх тухай мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

35.5. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 35.4-т заасан хугацааг нэг сар хүртэл хугацаагаар сунгуулах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.

35.6. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 35.4, 35.5-д заасан хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулж ирүүлээгүй бол оюуны өмчийн байгууллага мэдүүлэг гаргагчийг патентын мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, патентын мэдүүлгийг хэрэгсэхгүй болгосон тухай мэдүүлэг гаргагчид мэдэгдэл хүргүүлнэ.

35.7. Оюуны өмчийн байгууллага энэ хуулийн 35.1, 35.3, 35.4, 35.6-д заасан мэдэгдлийг мэдүүлэг гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

**36 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг салгах, нэгтгэх, өөрчлөлт оруулах, татгалзах**

36.1. Анхдагч огнооноос хойш мөн чанарын шүүлтийн явцад бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргагч хэдийд ч үйлчилгээний хөлс төлж дараах хүсэлтийг гаргах эрхтэй байна:

36.1.1.бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгээ хоёр болон түүнээс дээш бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт салгах тухай хүсэлт гаргах;

36.1.2.хамтаар ашиглагдах, эсхүл бүтээгдэхүүний загварын нэг ангилалд хамаарах бүтээгдэхүүний загварын хэд хэдэн патентын мэдүүлгийг нэгтгэх;

36.1.3.патентын мэдүүлэгтээ өөрчлөлт оруулах.

36.2.Энэ хуулийн 36.1.1-д заасны дагуу салгасан патентын мэдүүлэг тус бүр нь үндсэн патентын мэдүүлгийн анхдагч болон давамгайлах огноо авах эрхтэй. Салгасан патентын мэдүүлэг тус бүрд үйлчилгээний хөлс төлнө.

36.3.Мэдүүлэг гаргагч нь анхдагч огнооноос хойш мөн чанарын шүүлтийн явцад хэдийд ч бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгээсээ татгалзаж, хэрэгсэхгүй болгуулах эрхтэй.

### **37 дугаар зүйл.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх**

37.1.Оюуны өмчийн байгууллага бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг энэ хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шалгуурт нийцсэн эсэхийг тогтоох зорилгоор анхдагч огнооноос хойш есөн сарын дотор бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийж, тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

37.2.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан бол оюуны өмчийн байгууллага тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүний загварын ном зүй, тодорхойлолт, зургийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.

37.3.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг нь энэ хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шалгуурыг хангаагүй бол оюуны өмчийн байгууллага энэ тухай дүгнэлт гаргах ба түүнийг үндэслэн бүтээгдэхүүний загварт патент олгохоос татгалзах тухай урьдчилсан шийдвэр гаргаж, шүүлтийн тайлангийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

37.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 37.3-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээж авснаас хойш нэг сарын дотор үндэслэл бүхий хариуг оюуны өмчийн байгууллагад ирүүлнэ.



37.5.Оюуны өмчийн байгууллага энэ хуулийн 37.4-т заасан хариуг хүлээж авснаас хойш нэг сарын дотор тухайн бүтээгдэхүүний загварт патент олгох эсэх талаар эцсийн шийдвэр гаргаж, шийдвэрийг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

37.6.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 37.4-т заасан хариуг зохих хугацаанд ирүүлээгүй бол оюуны өмчийн байгууллага тухайн бүтээгдэхүүний загварт патент олгохоос татгалзах тухай эцсийн шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

37.7.Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх журмыг оюуны өмчийн байгууллага батална.

37.8.Албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн бүтээгдэхүүний загварыг патент олгох хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авах бөгөөд энэ хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр уг бүтээгдэхүүний загварыг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ПАТЕНТ ОЛГОХ, ПАТЕНТЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА, ПАТЕНТЫН ХУРААМЖ**

#### **38 дугаар зүйл. Сонирхогч этгээдийн эсэргүүцэл**

38.1.Энэ хуулийн 25.5, 37.2-т заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш гурван сарын дотор сонирхогч этгээд дараах үндэслэлээр оюуны өмчийн байгууллагад эсэргүүцэл гаргаж болно:

38.1.1. шинэ бүтээл нь энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй;

38.1.2. бүтээгдэхүүний загвар нь энэ хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй.

38.2.Энэ хуулийн 38.1-д заасан хугацаанд эсэргүүцэл гаргасан бол оюуны өмчийн байгууллага нь эсэргүүцэл хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор анхны шинжээчийг оролцуулахгүйгээр гурван шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр мөн чанарын шүүлт дахин хийж, дүгнэлт гаргаж, сонирхогч этгээд болон мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

38.3.Сонирхогч этгээд, эсхүл мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 38.2-т заасан дүгнэлтийг эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

38.4.Сонирхогч этгээд 38.3-т заасан хугацаанд Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргасан бол гомдлыг шийдвэрлэх хүртэл



оюуны өмчийн байгууллага патент олгох эсэх талаар шийдвэр гаргахыг хойшлуулна.

### **39 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент олгох**

39.1.Энэ хуулийн 25.5, 37.2-т заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш гурван сарын дотор сонирхогч этгээд эсэргүүцэл гаргаагүй бол оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар патент олгоно.

39.2.Ашигтай загвар нь энэ хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тухай мөн чанарын шүүлтийн дүгнэлтэд үндэслэн ашигтай загварын патент олгоно.

39.3.Оюуны өмчийн байгууллага шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентыг цаасан, эсхүл цахим хэлбэрээр олгож болно.

39.4.Патентын загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **40 дүгээр зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын хүчинтэй хугацаа**

40.1.Патент нь дараах хугацаанд хүчинтэй байна:

40.1.1.шинэ бүтээлийн патент анхдагч огнооноос хойш 20 жил;

40.1.2.ашигтай загварын патент анхдагч огнооноос хойш 10 жил;

